

## Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн

### ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг  
оны 9-р сарын 24

Иргэдийн хөгжлийн төв

2015

#### Ханбогд сум

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ээлжит хоёр дах удаагийн хурал 2015 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Уулзалтанд Ханбогд сумын төлөөлөл, Малчдын төлөөлөл, **ОюуТолгой ХХК-ийн төлөөлөл болон** Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газрын чиглүүлэгч нар болон бусад ажиглагч нар оролцов.

Уулзалтаар 7 дугаар сарын 1-нд хуралдсан Зөвлөлийн анхны хурлаас гарсан шийдвэрийн дагуу Хөндлөнгийн шинжээчдийн I шатны үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн тайланг сонсож, сайжруулах арга замыг хэлэлцэж тохирлоо. Мөн Ханбогд сумын МАА салбарыг 2016-2025 онд хөгжүүлэх хөтөлбөрийн төсөлтэй товч танилцаж санал өглөө. Ханбогд сумын Засаг даргын 2015 оны 8 дугаар сарын 28-ны 01/177 албан тоотоор ирүүлсэн албан хүсэлтийг хэлэлцэж, Засаг даргын 2011 оны 59 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үүргийг Гурван талт зөвлөлд хүлээн авахаар шийдвэрлэв.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх Олон талт шинжээчдийн багийг шалгаруулах үйл ажиллагааг эхлүүлэв. Түүнчлэн Гурван талт зөвлөлийн дүрэмд өмнөх хурлаар тохирсны дагуу бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажууллаа.

### Ханбогд сумын Гурван талт зөвлөл

#### Гурван Талт Зөвлөлийн тухай

Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт **гарын үсэг** зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмений газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГбол Дэлхийн

банкны группын Олон улсын санхүүгийн корпорацид чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.